



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/168

Хэрлэн сум

Байнгын байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын нутаг дэвсгэрт байрлах Зэвт дуулга ХХК-ийн Ямаат нэртэй MV-017189 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршлыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.

2. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг Зэвт дуулга ХХК-д зөвлөсүгэй.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүй бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/, Батноров сумын Засаг дарга /Г.Тайванжаргал/ нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах аюулгүйн ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Ж.Болд/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дугаар сарын 05 өдрийн 4/168
дугаар захирамжийн хавсралт



Зэвт дуулга ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис,
тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршил

д/д	Х	Ү
1	47 59 46.439	111 26 37.472
2	47 59 49.316	111 26 40.111
3	47 59 47.437	111 26 44.307
4	47 59 44.518	111 26 41.649